

Ажлын гүйцэтгэлийг сайжруулах талаар  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн “а”, 29.2, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 3/08 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ажлын гүйцэтгэл, үр дүнг сайжруулах зорилтын хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т даалгасугай:

1/Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааг энэ захирамжийн хавсралтад заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлэх ажлыг туршилтын журмаар эхлүүлж, дүнг 2018 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулах;

2/энэ захирамжийн хавсралтад заасан шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, 2018 оны II улиралд багтаан танилцуулах.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

С.БАТБОЛД

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт /цаашид “шалгуур үзүүлэлт” гэх/ нь хууль тогтоомж, Засгийн газар болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн тухайн жилийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд агентлагуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тооцож, гүйцэтгэлийн менежментийг сайжруулахад чиглэнэ.

### Хоёр. Мэдээллийн эх үүсвэр

2.1.Шалгуур үзүүлэлтийг тооцоход дараахь байгууллагаас гаргадаг албан ёсны болон захиргааны статистик мэдээллийг ашиглана:

2.1.1.статистикийн байгууллага;

2.1.2.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг.

### Гурав. Нийтлэг шалгуур үзүүлэлт

3.1.Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааг дараахь нийтлэг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:

3.1.1.Албан бичиг шийдвэрлэлтийн индекс: Байгууллагын нийт албан хаагчдын албан бичиг шийдвэрлэлтийн үзүүлэлтийг Албан бичгийн хяналт, шийдвэрлэлтийн системээс тооцож гаргана (edoc.ub.gov.mn);

3.1.2.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн индекс: Байгууллагын нийт албан хаагчдын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үзүүлэлтийг “Өргөдөл гомдлын хяналт, шийдвэрлэлтийн систем” -ээс тооцож гаргана (smartcity.mn);

3.1.3.Үүрэг, даалгаврын гүйцэтгэлийн түвшин: Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн болон Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын гүйцэтгэлийг “Үүрэг даалгавар, гүйцэтгэл, хяналтын системээс тооцож гаргана (Leader Monitoring);

3.1.4.Тусгай захиалгат ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн түвшин:

Нийслэлийн Засаг даргын захиалгаар хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн түвшин.

## Дөрөв. Тусгай шалгуур үзүүлэлт

### 4.1.Нийслэлийн Авто замын хөгжлийн газар

4.1.1.Тээврийн хэрэгслийн зогсоол: Нийслэл дэх тээврийн хэрэгслийн зогсоолын тоо, хэмжээний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.1.2.Олон түвшний огтлолцол: Төмөр замтай огтлолцсон зам, уулзвар дахь гүүрэн гарц, огтлолцлын тоо, хэмжээний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.1.3.Хатуу хучилттай авто замын сүлжээний урт: Нийслэл хотын авто замын сүлжээний хатуу хучилттай замын уртын өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.1.4.Авто замын сүлжээний гүүрэн байгууламжийн урт: Нийслэл хотын авто замын сүлжээн дэх гүүрийн уртын өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.1.5.Төмөр замаар тусгаарлагдсан гудамж, замуудыг холбосон нүхэн гарц: Төмөр замын доогуурх нүхэн гарцын тоо, хэмжээний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.1.6.Авто замын гол болон туслах гудамж, замуудын өргөтгөл, шинэчлэлт: Өргөтгөж шинэчилсэн авто замын уртын өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ.

### 4.2.Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар

4.2.1.Нийслэлийн түүхий нүүрсний хэрэглээ: Нийслэлийн түүхий нүүрсний хэрэглээний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.2.2.Агаарын чанарын өөрчлөлт: Нийслэлийн нэг жилийн агаарын тоосжилтын дунджийн өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ

4.2.3.Усан халаалтын зуух болон хөдөлгөөнт эх үүсвэрүүдийн түлшний чанар: Усан халаалтын зуух болон хөдөлгөөнт эх үүсвэрүүдийн түлшний чанарын өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.2.4.Агаарын чанарыг доройтуулж байгаа бодисын хэрэглээ, бохирдуулагч эх үүсвэр, физикийн хортой нөлөөлөл: Агаарын чанарыг доройтуулж байгаа бодисын хэрэглээ, бохирдуулагч эх үүсвэр, физикийн хортой нөлөөллийн өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ.

### 4.3.Нийслэлийн Архивын газар

4.3.1.Төрийн архивын цаасан болон цахим баримтын бүрдүүлэлт: Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын архивын баримт бүрдүүлэлтийн ажлын үр дүн, нөхөн бүрдүүлсэн баримтын тоо, хэмжээний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.3.2.Цахим мэдээллийн сан, түүний баяжуулалт: Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын баримт мэдээллийг цахим санд оруулсан өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ.

#### 4.4.Нийслэлийн Аялал жуулчлалын газар

4.4.1.Эдийн засагт оруулах хувь нэмэр: Улаанбаатар хотод хүрэлцэн ирсэн гадаадын жуулчдын тоо, салбарын орлогын өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.4.2.Жуулчдын аюулгүй байдал: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гэмт хэрэгт өртсөн гадаадын жуулчдын тооны өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.4.3.Улаанбаатар хотод аялсан гадаадын жуулчдын сэтгэл ханамж: Жуулчдын санал, сэтгэгдлээр илэрхийлнэ;

4.4.4.Жуулчны үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмж: Жуулчны байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийн хувийн өөрчлөлтөөр илэрхийлнэ.

#### 4.5.Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо

4.5.1.Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин: Сорилд хамрагдсан нийт хүнээс А, В, С түвшинд үнэлэгдсэн хүний тооны өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.5.2.Биеийн тамир, спортоор хичээллэгч иргэдийн тоо: Биеийн тамир, спортын секц, дугуйлан, бялдаржуулах, чийрэгжүүлэх төвүүдэд тогтмол хичээллэгчдийн нийт хүн амд эзлэх хувийн өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.5.3.Биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмж: Нийслэлийн нэг оршин суугч, иргэнд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэхэд ногдож байгаа зардлын хэмжээний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ.

#### 4.6.Нийслэлийн Боловсролын газар

4.6.1.Цэцэрлэгт хамран сургалтын индекс: Тухайн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих 2-5 насны нийт хүүхдээс цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн хувийн өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.6.2.Бага боловсролын хамран сургалтын индекс: Тухайн жилд бага боловсролд хамрагдвал зохих 6-10 насны нийт хүүхдээс ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа 6-10 насны хүүхдийн хувийн өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.6.3.Суурь боловсролын хамран сургалтын индекс: Тухайн жилд суурь боловсролд хамрагдвал зохих 6-14 насны нийт хүүхдээс ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа 6-14 насны хүүхдийн эзлэх хувийн өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.6.4.Хүүхдийн авьяас, сонирхол хөгжлийн индекс: Тухайн жилд дугуйлан, уралдаан тэмцээн, хүүхдийн оролцооны байгууллагад хамрагдсан дунд,

ахлах ангийн хүүхдийн нийт ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа дунд, ахлах ангийн хүүхдийн дотор эзлэх хувийн өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.6.5.Нэг багшид ноогдох хүүхдийн тоо: Ерөнхий боловсролын сургуулийн нийт багш, сурагчийн тооны харьцааны өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.6.6.Сургууль, цэцэрлэгийн хүртээмж: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тоо болон сургууль, цэцэрлэгт суралцагчдын тооны харьцааны өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ.

#### 4.7.Нийслэлийн Газрын алба

4.7.1.Нийслэлийн орлого бүрдүүлэлт: Нийслэлийн төсөвт хуримтлуулсан газрын төлбөрийн гүйцэтгэлийн хувийн өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.7.2.Газар чөлөөлөлт: Улс болон нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд барих зам, барилга байгууламж болон газрын тухай хууль тогтоомжийн зөрчлийг арилгах зорилгоор явуулсан газар чөлөөлөх ажлын гүйцэтгэл, үр дүнгээр илэрхийлнэ;

4.7.3.Газар олголт: Тухайн жилд иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахаар гаргасан нийт шийдвэрт эзлэх газрын тухай хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийн хувиар дүгнэнэ.

#### 4.8.Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар

4.8.1.Эрсдэлтэй орон сууц, объект: Зориулалтыг нь өөрчилсөн, хүчитгэсэн, эсхүл буулгасан эрсдэлтэй орон сууц, объектуудын тооны өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.8.2.Зөвшөөрөлгүй баригдсан барилга: Нийслэлд шинээр баригдсан объект, орон сууцны дотор зөвшөөрөлгүй баригдсан барилга байгаа эсэх, хэрэв байгаа бол уг барилгын талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнгээр илэрхийлнэ;

4.8.3.Барилга байгууламжийн хянан баталгаажуулалт: Нийслэлийн нутаг дэвсгэр дэх барилга байгууламжийг гэрчилгээжүүлэх, тэдгээрийн чанар, насжилт, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг хянан баталгаажуулах ажлын үр дүнгээр илэрхийлнэ.

#### 4.9.Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар

4.9.1.Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд ашиглалтад орсон орон сууц: Дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд орон сууцанд шинээр орсон өрх болон орон сууцанд орох шаардлагатай өрхийн харьцааны өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.9.2.Гэр хорооллын дэд бүтэц: Дахин төлөвлөлтийн ажлын хүрээнд гэр хорооллын нутаг дэвсгэрт шинээр барьж, ашиглалтад оруулсан дэд бүтэц, инженерийн байгууламжийн өөрчлөлтөөр илэрхийлнэ.

#### 4.10.Нийслэлийн Дотоод аудитын алба

4.10.1.Төлөвлөгөөт болон захиалгат аудитын үр дүнд илэрсэн зөрчил: Төлөвлөгөөт болон захиалгат аудитын үр дүнд илэрсэн зөрчлийн тоо, түүнийг арилгуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгээр илэрхийлнэ.

#### 4.11.Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар

4.11.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Нийслэлийн залуучуудыг байнгын, тогтвортой ажлын байраар хангах зорилгоор авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр илэрхийлнэ;

4.11.2.Хорт зуршил, тэдгээртэй холбоотой гэмт хэрэг, өвчлөл, донтолт: Хорт зуршил, тэдгээртэй холбоотой гэмт хэрэг, өвчлөл, донтолтыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгээр илэрхийлнэ;

4.11.3.Залуучуудын нийгмийн оролцоо, идэвхи, санаачилга: Төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд оролцсон залуучуудын тооны өөрчлөлт болон уг арга хэмжээний үр дүнгээр илэрхийлнэ.

#### 4.12.Нийслэлийн Мал эмнэлгийн газар;

4.12.1.Мал, амьтны өвчний халдварлалтын түвшин: Тухайн дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт оношлогдсон мал, амьтны өвчлөлтийн түвшингээр илэрхийлнэ;

4.12.2.Эм, био бэлдмэл, багаж төхөөрөмжийн чанар, хүртээмж: Эм, био бэлдмэл, багаж төхөөрөмжийн захиалга, татан авах, хадгалах, хуваарилах, зарцуулах, эмийн нөөцийн хангамжийн түвшингээр илэрхийлнэ;

4.12.3.Мал, амьтны халдварт, гоц халдварт, паразит өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэлтийн түвшин: Мал, амьтны халдварт, гоц халдварт, паразит өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнгээр илэрхийлнэ.

#### 4.13.Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар

4.13.1.Хяналт шалгалтын объектын эрсдэлийн түвшин: Тухайн жилийн төлөвлөгөөт хяналт шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн хяналт шалгалтын объектын өсөлт, бууралтын хувиар илэрхийлнэ;

4.13.2.Хяналтын байгууллагын зөвлөн туслах үйлчилгээний түвшин: Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт аюулгүй ажиллагаа, чанар стандарт, технологийн шаардлагыг хангуулах чиглэлээр үзүүлсэн зөвлөн туслах үйлчилгээний тооны өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.13.3.Хяналт, зөвлөн туслах ажлын үр нөлөө: Тухайн жилийн төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээний үр нөлөөгөөр илэрхийлнэ.

#### 4.14.Нийслэлийн Нийгмийн даатгалын газар

4.14.1.Тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээний хүртээмж: Хуулийн

хугацаанд тэтгэвэр, тэтгэмж авсан иргэдийн нийт тэтгэвэр, тэтгэмж авах иргэдийн дотор эзлэх хувиар илэрхийлнэ;

4.14.2.Нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмж: Нийслэлийн нэг цэгийн үйлчилгээний төвүүд болон дүүргүүдийн нэг цонхны үйлчилгээгээр дамжуулан нийгмийн даатгалын үйлчилгээ авч байгаа иргэдийн нийт даатгуулагчид дотор эзлэх хувиар илэрхийлнэ;

4.14.3.Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх дундаж хугацаа: Нэг иргэнд үйлчлэхэд зарцуулах хугацааны өөрчлөлтөөр илэрхийлнэ.

#### 4.15.Нийслэлийн Нийгмийн халамжийн газар

4.15.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн стандартын түвшин: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх зорилгоор барьсан барилга байгууламж, зам талбай нэмэгдсэн эсэхээр үнэлнэ;

4.15.2.Нийгмийн халамж, үйлчилгээнд хамруулсан түвшин: Нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлсэн орц, траншейнд хоноглодог орон гэргүй тэнэмэл болон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой айл өрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тооны өөрчлөлт, уг арга хэмжээний үр дүнгээр илэрхийлнэ.

#### 4.16.Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар

4.16.1.Техникийн засвар, үйлчилгээний чанар: Үйлчлүүлэгч байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн нийт санал, хүсэлтэд нийслэлийн төр, захиргааны байруудын инженерийн байгууламжийн талаарх гомдлын эзлэх хувиар илэрхийлнэ;

4.16.2.Цэвэрлэгээ, үйлчилгээний чанар: Иргэд, албан хаагчдаас ирүүлсэн нийт санал, хүсэлтэд нийслэлийн төр, захиргааны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээний талаарх гомдлын эзлэх хувиар илэрхийлнэ;

4.16.3.Нийтийн хоолны үйлчилгээний чанар: Үйлчлүүлэгчдээс ирүүлсэн нийт санал, хүсэлтэд зоогийн газрын хоолны үйлчилгээ болон хүлээн авалт, захиалгат зоогийн үйлчилгээний талаарх гомдлын эзлэх хувиар илэрхийлнэ.

#### 4.17.Нийслэлийн Улсын бүртгэлийн газар

4.17.1.Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж: Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулах, хүнд суртлыг бууруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр авсан арга хэмжээний үр дүнгээр илэрхийлнэ;

4.17.2.Төлбөрийн чадваргүй, бичиг баримтын зөрчилтэй иргэдийн асуудлын шийдвэрлэлт: Оршин суух хаягтай боловч төлбөрийн чадваргүйн улмаас бичиг баримтын зөрчилтэй иргэдийн санд бүртгэлтэй иргэдийг бичиг баримтжуулсан ажлын үр дүнгээр илэрхийлнэ.

#### 4.18.Нийслэлийн Онцгой байдлын газар

4.18.1.Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлын хүртээмж: Газар хөдлөлт, үер, зуд зэрэг аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийслэлийн оршин суугч, иргэдийн дунд зохион байгуулсан сургалт, сурталчилгааны ажлын тоо, үр дүнгээр илэрхийлнэ;

4.18.2.Объектын болон ой хээрийн түймрийн гаралт: Нийслэлийн нутаг дэвсгэрт тохиолдсон аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, гал түймрийн тоо, учирсан хохирлын хэмжээг харгалзан дүгнэнэ.

#### 4.19.Нийслэлийн Өмчийн харилцааны газар

4.19.1.Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн байдал: Нийслэлийн тухайн жилийн төсөв, төлөвлөгөөнд тусгагдсан түрээсийн төлбөрийг хугацаанд нь нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн эсэхээр дүгнэнэ;

4.19.2.Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын үр ашиг: Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтын үр ашиг нэмэгдсэн эсэхээр дүгнэнэ.

#### 4.20.Нийслэлийн Статистикийн газар

4.20.1.Албан ёсны статистикийн мэдээний бодит байдал: Тайлант хугацаанд мэдээнд хамрагдвал зохих нийт нэгжээс мэдээнд хамрагдсан нэгжийн эзлэх хувийн жин;

4.20.2.Тооллого, судалгаа: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгааны гүйцэтгэлийн түвшин;

4.20.3.Мал, тэжээвэр амьтдын тооллого: Тооллого, судалгааны бэлтгэл ажил, зохион байгуулалт, мэдээллийн чанар, мэдээлэл дамжуулалт тус бүрд өгсөн зохих үнэлгээгээр тооцно;

4.20.4.Мэдээллийн хүртээмж: Статистикийн сургалт, сурталчилгаа, мэдээлэл тархаасан байдлаар дүгнэнэ;

4.20.5.Статистикийн үйл ажиллагаагаар дамжуулан хэрэглэгчдэд тогтмол хүргэсэн мэдээллийн хүртээмжээр илэрхийлнэ;

4.20.6.Аз жаргалтай хотын индекс: Тоон үзүүлэлтийн боловсруулалтын түвшингээр илэрхийлнэ.

#### 4.21.Нийслэлийн Соёл, урлагийн газар

4.21.1.Соёл, урлагийн байгууллагын 1000 хүнд ногдох суудлын тоо: Нийслэлийн соёл, урлагийн байгууллагын суудлын тоо болон нийт оршин суугчдын тооны харьцааны өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.21.2.Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж: Нийслэлийн соёл, урлагийн байгууллагуудын тухайн жилд хотын оршин суугчдад үзүүлсэн үйлчилгээний тооны өөрчлөлтөөр илэрхийлнэ;



4.21.3.Нийслэл хотын түүх, соёлыг сэргээн сурталчлах, соёлын бизнес-аялал жуулчлал: Нийслэл хотын түүх, соёлыг сэргээн сурталчлах, соёлын бизнес-аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны цар хүрээ, үр нөлөөгөөр илэрхийлнэ;

4.21.4.Түүх, соёлын дурсгалт зүйлсийн археологи, архитектур, соёлын өв, урлагийн үнэт бүтээлийг хадгалах, хамгаалах, сурталчлах, сэргээн засварлалт: Түүх, соёлын дурсгалт зүйлсийн археологи, архитектур, соёлын өв, урлагийн үнэт бүтээлийг хадгалах, хамгаалах, сурталчлах, сэргээн засварласан тоо хэмжээний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ

#### 4.22.Нийслэлийн Татварын газар

4.22.1.Татвар төлөгчдөд үзүүлсэн үйлчилгээний чанар, хүртээмж: Үйлчилгээг хялбаршуулах, хүнд суртлыг бууруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр авсан арга хэмжээний үр дүнгээр илэрхийлнэ;

4.22.2.Татварын орлогын биелэлт: Татварын орлогын төлөвлөгөөний биелэлт болон татварын орлогын нийслэлийн төсвийн орлогод эзлэх хувиар илэрхийлнэ.

#### 4.23.Нийслэлийн Тээврийн газар

4.23.1.Нийслэлийн тээврээр зорчсон нийт зорчигчдын тоо, зорчигч эргэлт: Нийслэлийн хэмжээнд тээвэрлэсэн нийт зорчигч, зорчигч эргэлтийн хэмжээний өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.23.2.Нийтийн зорчигч тээврийн хэрэгслийг хүлээх дундаж хугацаа: Хот доторх нийтийн зорчигч тээврийн маршрут бүрээр тооцсон тээврийн хэрэгслийг хүлээх дундаж хугацааны өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.23.3.Ачаа тээврийн үр ашиг: Ачаа тээврийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх талаар авсан зохион байгуулалтын арга хэмжээний үр дүнгээр илэрхийлнэ.

#### 4.24.Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар

4.24.1.Ажилгүйдлийн түвшин: Нийслэлийн хүн амын ажилгүйдлийн түвшингийн өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.24.2. 15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажилгүйдэл буурсан эсэх, нийслэлийн хөдөлмөрийн насны нийт иргэдээс хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн эзлэх хувийн өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.24.3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ өөрчлөгдсөн эсэхээр дүгнэнэ.

#### 4.25.Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар

4.25.1.Нэг хүнд ногдох төмс, хүнсний ногооны тоо хэмжээ /дотоодын/: Нийслэлийн нэг хүнд ногдох төмс, хүнсний ногооны тоо, хэмжээний өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.25.2.Нэг хүнд ногдох жимс, жимсгэнийн тоо хэмжээ /дотоодын/: Нийслэлийн нэг хүнд ногдох жимс, жимсгэний тоо, хэмжээний өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.25.3.Нэг хүнд ногдох сүү, сүүн бүтээгдэхүүний тоо, хэмжээ /дотоодын/: Нийслэлийн нэг хүнд ногдох сүү, сүүн бүтээгдэхүүний тоо хэмжээний өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.25.4.Нэг хүнд ногдох мах, махан бүтээгдэхүүний тоо, хэмжээ /дотоодын/: Нийслэлийн мах, махан бүтээгдэхүүний хангамжийн /урд оны/ тоо, хэмжээг тухайн оны үзүүлэлттэй харьцуулж хувьд шилжүүлж тооцно;

4.25.5.Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын түвшин: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдийн үйлдвэрлэсэн хүнс, хүнсний бүтээгдэхүүний тоо, хэмжээний өөрчлөлтөөр илэрхийлнэ.

#### 4.26.Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар

4.26.1.Сургууль завсардалтын түвшин: Суурь боловсрол (1-9 анги хүртэл) эзэмших насны (7-16 насны) хүүхдийн дотор сургуульд суралцахгүй байгаа хүүхдийн эзлэх хувийн өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.26.2.Хараа хяналтгүй хүүхдийн түвшин: Эцэг, эх болон ах, дүү, хамаатан садан байхгүй болон бусад шалтгаанаар гадуур тэнэж хоноглодог, хараа хяналтгүй хүүхдийн тоо буурсан эсэхээр дүгнэнэ;

4.26.3.Хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн түвшин: Нийслэлийн нийт хүүхдийн дунд хөдөлмөр эрхэлж байгаа нь бүртгэгдсэн хүүхдийн эзлэх хувийн өөрчлөлтөөр илэрхийлнэ.

#### 4.27.Нийслэлийн Цагдаагийн газар

4.27.1.Гэмт хэргийн түвшин: Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэрэг болон оршин суугчдын тоон харьцаа, өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.27.2.Захиргааны зөрчлийн түвшин: Бүртгэгдсэн зөрчлийн тоон үзүүлэлт болон оршин суугчдын тоон харьцаа, өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ;

4.27.3.Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн түвшин: Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг цэгийн тоо болон бүртгэгдсэн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтийн өөрчлөлтөөр илэрхийлнэ.

#### 4.28.Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар

4.28.1.Startup компани: Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд байгуулагдсан гарааны компаниудын тоо нэмэгдсэн эсэхээр дүгнэнэ;

4.28.2.Боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний өөрчлөлт: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа

боловсруулах үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.28.3.Инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний өөрчлөлт: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, газруудын инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдсэн эсэхээр дүгнэнэ.

#### 4.29.Нийслэлийн Эрүүл мэндийн газар

4.29.1.Дархлаажуулалтын түвшин: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн эсэхээр дүгнэнэ;

4.29.2.Урьдчилан сэргийлэх үзлэгийн түвшин: Нийслэлийн хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хувь хэмжээний өөрчлөлтөөр илэрхийлнэ;

4.29.3.Нийт төрөлтөд эзлэх хяналтгүй төрөлтийн түвшин: Нийслэлийн нутаг дэвсгэрт төрсөн нийт төрөлтөд хяналтгүй төрөлтийн эзлэх хувь буурсан эсэхээр дүгнэнэ;

4.29.4.Үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх иргэдийн сэтгэл ханамж: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн иргэдийн дотор гомдол гаргасан иргэдийн эзлэх хувь буурсан эсэхээр дүгнэнэ.

#### 4.30.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар

4.30.1.Худалдан авах ажиллагааг зохион байгуулах хугацаа: Худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжин ирсэн өдрөөс гэрээ байгуулах зөвлөмж хүргэх хүртэлх хугацааг харгалзан дүгнэнэ;

4.30.2.Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй, шударга байдал: Тендерийн үйл ажиллагаатай холбогдуулан иргэд, байгууллагаас гаргасан гомдлын нийт зарласан тендерт эзлэх хувиар илэрхийлнэ;

4.30.3.Зөрчилтэй худалдан авах ажиллагааны түвшин: Хууль тогтоомж зөрчсөн үндэслэлээр эрх бүхий байгууллагаас хүчингүй болгосон тендерийн нийт зарласан тендерт эзлэх хувиар илэрхийлнэ.

#### 4.31.Нийслэлийн Мэдээллийн технологийн газар

4.31.1.Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлсэн байдал, эдийн засгийн үр ашиг нэмэгдсэн эсэхээр илэрхийлнэ;

4.31.2.Нийслэлийн нэгдсэн сүлжээний дэд бүтцийн хангамж нэмэгдсэн эсэхээр дүгнэнэ;

4.31.3.Нийслэлийн дата төвийн сүлжээ, сервер, тоног төхөөрөмжийн ажиллах нийт хугацааг, хэвийн бус ажилсан хугацаанд харьцуулсан харьцаагаар дүгнэнэ;

4.31.4.Мэдээллийн аюулгүй байдлын түвшин: Төрийн захиргааны бүх төрлийн баримт бичиг, мэдээ мэдээлэл устгагдах, зүй бусаар нийтэд тараагдах, халдлагад өртөх эрсдэлийн түвшингийн хувиар илэрхийлнэ.

#### 4.32.Нийслэлийн Байгаль орчны газар

4.32.1.Ойжуулалт хийсэн талбай: Нийслэлийн нутаг дэвсгэрт тухайн жилд ойжуулалт хийсэн талбайн хэмжээгээр илэрхийлнэ;

4.32.2.Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийсэн талбай: Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжүүдийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээгээр илэрхийлнэ;

4.32.3.Хүнд металлын бохирдлыг саармагжуулсан талбай: Иргэн, аж ахуйн нэгжийн болон нийтийн эзэмшлийн талбай дахь хүнд металаар бохирдсон цэгийн бохирдлыг саармагжуулсан хэмжээгээр илэрхийлнэ;

4.32.4.Хамгаалалтад авч тохижуулсан булаг, шанд: Нийслэлийн нутаг дэвсгэрт хашиж, хамгаалсан булаг шандын эхийн тоогоор илэрхийлнэ;

4.32.5.Төлбөр, хураамжийн бүрдүүлэлт: Нийслэлийн төрийн сангийн дансанд байршуулах байгалийн нөөц баялаг ашигласны төлбөр, хураамжийн гүйцэтгэлийн түвшингээр илэрхийлнэ.

-----oOo-----